

Р.Ф. УНГЕРНИЙ МОНГОЛ ДАХЬ АЖИЛЛАГАА**С.ДАМДИНСҮРЭН****I**

Барон Р.Ф.Унгерний нэр, үйл ажиллагаа нь 1920-1921 оны Монголын улс төрийн амьдрал, Монголын тусгаар тогтнолын эрх ашгийг хөндсөн амин чухал асуудлуудтай холбоотой юм.

Монгол орныг түрэмгийлэн эзэлсэн Хятадын цэргийн дарангуйлагч дэглэм хүчээ авч улам харгис хэршгий болж, урьдын худалдаачид, мөнгө хүүлэгчид эргэн ирж хуучин өрөө нэхэхийн хамт, ард түмнийг цэрэг-улс төр, эдийн засгийн шинэ шинэ дарамтанд оруулсан үе байв. Монголын автономийг устгасны дараа дээд лам, ноёдын олонхи нь Хятадад лагаар орох аваас урьдахаасаа ч илүү дарлал, зовлон амсах болно гэдгийг төсөөлж байсан учир гадаадын тусламж эрэлхийлж зарим нь Америкаас зарим нь Япон ба цагаантнаас тусламж горилох болсон юм. Япон ба цагаантнаас тусламж гуйх бичигт шадар сайд, сэцэн ван Гүрсоронзонгомбосүрэнээр уламжлан Богдын тамгыг даруулж, гүн Рагчаагаар¹ явуулсан мэдээ бий. Энэ нь барон Унгерний Монголд орж ирэх нэгэн шалтаг болжээ.

Унгернийг Монголд ирэхэд нөлөөлсөн гол шалтгаан нь түүний улс төрийн үзэл баримтлал, зорилгод нь оршино. Унгерн хувьсгалыг оролцуулан бүх гамшиг зовлонг төрүүлсэн, устах тийшээ хандсан гэж үзээд өрнөдийн соёл иргэншилд урам нь хугарч сэтгэл алдарсан нэгэн байжээ. Иймээс дорнын соёл, буддизмд татагдах болсон юм байна. Хөгжлийг урагш дэвшүүлэх үүргийг хэрэгжүүлэгч хүч бол шар арьстнууд, дорнын соёл, юуны өмнө байгалийн онгон ариун байдал, буянт үйлийг хадгалсаар буй төв Азийн нүүдэлчид, монголчууд мөн гэж үзжээ. Тэрээр нэгэн байцаалт дээр “Дорнодын ахуйн бүх хэвшил, бүх нарийн утгаараа онцгой сэтгэл татдаг юм”² гэж хэлсэн байдаг. Түүний улс төрийн үзлийн үндэс нь хаант засгийг нийгмийн байгууламжийн хамгийн шилдэг хэлбэр гэх үзэж байв. Тиймээс өөрийн улс төрийн гол зорилго бол газар сайгүй хаант засгийг тогтоох явдал тул Манж Чин улсын хаанчлал, Оросын Романовын угсаанхы нь, хаанчлалыг сэргээн мандуулахыг тэрээр түүхэн үүргээ гэж үздэг байжээ. Энэ чиглэлд хийх анхны алхам бол Монголд

¹ С.Дамдинсүрэн - ШУА-ийн Олон улс судлалын хүрээтэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D)

Богд гэгээний шашин, төрийг хосолсон хаант засгийг сэргээх явдал мөн гэж үзсэн байна.

Монгол аймгуудыг нэгтгэж Чингис хааны гүрнийг хэсэг хэсгээр ч атугай сэргээх Семеновын үзэл санаа, Унгерний “Их Монголын” тухай болдол, Азийн төвд бэхжихийг эрмэлзэгч Японы глобал зорилго нь “нармай Монголын” үзэл гэсэн нэг цэг дээр нийлж байв. Даурын засгийн ажил анхнаасаа хүч авч чадалгүй байсаар сульдан зогсож түүний толгойлогчдын нэг болох атаман Семенов улаан армийн давшилтанд тал талаас шахагдаж Манжуурт зайлан гарах болсон үед барон Унгерн Монголыг зорихоор шийджээ. Унгерний ийнхүү шийдсэн нь санамсаргүй биш юм. Хятадын түрэмгийллийн улмаас олон түмний дургүйцэл, эсэргүүцэл ихэсч эрх баригчид нь гаднын тусламж эрж буй үед нь Монголд нэвтрэн гэминг дийлбээс нэгд, өөртөө түр ч гэсэн хоргодох орон зай олох, хоёрт, монголд үлэмж нэр хүнд, дэмжлэгтэй болж зорьсон хэргээ бүтээх магадлалтай гэж найджээ. Унгерн урьд нь Монголд ирэхийг ямагт мөрөөдөж, боломжийг хүлээж байжээ. Тэрээр бүр 1910 онд Хүрэн дэх Оросын консулын хамгаалалтын албанд офицер байх үеэс Монголыг сонирхох болсон бөгөөд Орост буцсаныхаа дараа ч 1911-1912 оны үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцлийн тухай мэдээ сэлтэй танилцаж Монголд ажиллах хүсэлт тавьжээ. Гэвч түүний хүсэлтийг зөвшөөрөөгүй тул тэрээр цэргээс бэлтгэлээр халагдаж 1913 онд хувийн журмаар Монголд ирээд Дамбийжанцаны отрядад нэгдэн улмаар Хятадын цэргийн эсрэг тэмцэлд орохоор Ховдод очсон байна. Гэтэл Ховд дахь Оросын консул түүний Дамбийжаатай нэгдэхийг эрс хориглосон юм. Унгерн Ховдод хагас жил болохдоо хятад, монгол хэл судалж монголчуудын зан заншил, шашин шүтлэгийг нэлээд сайн мэдлэг болжээ.

Унгерн тийнхүү 1920 оны 10 дугаар сарын 2-нд Монголын дорнод хязгаараар 800 орчим хүнтэй Азийн морин дивизээ удирдан орж ирээд дотогшлон явсаар Сан бэйсийн хошууны (Баянтүмэн) хойт захад сэмхэн ирж буудаллажээ. Тэрээр тохиолдсон хүн бүрд Монголыг Хятадын ноёрхлоос чөлөөлнө, Богд-гэгээнийг хаан ширээнд нь эгүүлэн залж автономыг сэргээнэ, Монгол овогтныг нэгтгэнэ, шарын шашныг мандуулна хэмээн ятган ухуулж, гэмингийн харгислалд өширсөн хүмүүст хялбархан үнэмшүүлж ихээхэн дэмжлэг хүлээх болжээ.

Хаант ёсны үзэл баримтлагч Унгернийг юуны урьд монголын нөлөө бүхий ноёд, тухайлбал Лувсанцэвээн тэргүүн, Дугаржав Мэйрэн зэрэг хүмүүс угтан уулзаж Монголыг Хятадын дарлалаас ангижруулах хүчин хэмээн үзэж түүнд цэргийн хүнс, уналга нийлүүлэх, цэрэг элсүүлэх зэрэгт идэвхтэй туслан дэмжиж байв. Монгол ноёдын зөвлөснөөр Богд хааны зөвшөрлийг олохын тулд Унгерн бас Богд гэгээнд захидал бичиж

“Оросын хаан угсааны ураг барон Унгерн би Орос, Монголын язгуурын найртай сайны ёсоор Богд-хаан танд тус хийж, Монголыг харгис Хятадын дарлагдлаас ангижруулан хамгаалж тохиноулахын тухай цэрэг авч Хүрээнд орох зорилго бүхий тул олдвоос Богд хаантаас зөвшөөрөл олгож хариу ирүүлэх ажаамуу гэжээ. Энэ нь цагаантны тусламжийг хүссэн Богд хааны тамгатай бичгийн үзэл санаатай нийцсэн тул ихэд сайшан зөвшөөрсөн ажээ.³ 1920 оны 10 дугаар сарын 27-ос 11 дүгээр сарын 7 хүртэл Унгерний цэрэг Хүрээг хэд хэдэн удаа дайрсан боловч Хятад цэргийн давуу хүчинд няцаагдаж, хүчээ сэлбэхээр дорно зүг түр ухарчээ.

Ийнхүү барон Унгерн Монгол орны бүхий л дорнод хэсэгт бэхжсэн төдийгүй нийслэлд тулж ирснээр Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн явцад зэрэг ба сөрөгөөр нөлөөлсөн хүчин зүйл бий болов. Хятадууд Унгерний довтолгооныг далимдуулан үүний шалтгааныг монголчуудад тохон зэмлэж Хүрээнд онц байдал тогтоож, хятад цэргийн гол хүчийг төвлөрүүлжээ. Баруун бүх аймаг, Ховд-Улиастайн тойрогийг хятад цэргээр дүүргэв. Хятадуудын үйлдсэн дээрэм, аллага, хавчилга туйлын харгис шинжтэй болов. Богд гэгээн, Жалханз хутухт, Шанзоб, да лам Пунцагдорж, Сэцэн хан, манлай ван Дамдинсүрэн, Хатанбаатар Магсаржав, Ардын нам, түшмэдийн намын гишүүд - Жигмэд гүн, Жамъян гүн, Гомбо - Ичин, Лувсанжанцан зэрэг төр, нийгмийн нэрт зүтгэлтэн олон хүнийг баривчлан хорив. Лам нарыг олноор нь залхаан цээрлүүлж хурал номын үед нь ч буудах дээрэмлэх нь ерийн үзэгдэл болж монгол, буриад, оросуудыг өдөр бүр нэгжиж баривчилж байв. Энэ бүхнээс хүн амын дургүйцэл, хятадын цэргийг үзэн ядах нь туйлдаа хүрэв.

Ийм үед Унгерн шинэ довтолгоонд шаргуу бэлтгэж байв. Холбоотон монгол ноёдын дэмжлэгтэйгээр монголчуудаас цэрэгт дайчилж, уналга, ачилга, хүнс, хэрэгслээ базааж, зохион байгуулалт, суртал нэвтрүүлгийн ажлыг ч монголчуудын эрмэлзэл, сонирхолд нийцүүлэн явуулж байв. Энэ бүхний үр дүнд Унгерний монгол цэргийн тоо 200 байснаа нэг мянга хүрч⁴ 5 дахин өсчээ. Цэргийн зохион байгуулалтыг жигдрүүлэн анги, салбаруудыг хуваарилан захирагчдыг томилж, Орос цэргийн Жанжинд Унгерн, Монгол цэргийн жанжинд Лувсанцэвээн тохоогдов. Жанжны дэргэдэх яам хэмээхийг байгуулж түүнд: Сэцэн хан аймгийн баатар бэйл Жамъян, зоригт бэйс Мишигдорж, мөн хошууны гүнгийн зэрэг туслагч тайж Цэрэндорж, сэргэлэн гүн Дугарсүрэн, мэргэн гүн Цэрэнвандуйбавуудорж зэрэг хүмүүсийг оруулжээ. Лувсанцэвээний багш, зуугийн лам Ринчинсамбуу, Дэрин Чойжин хэмээгч хоёрыг цэргийн лам болгожээ.

II.

Ийнхүү зохих бэлтгэлээ хийсний дараа Унгерн 1921 оны 1 дүгээр сарын 24-ний өглөө Нийслэл хүрээг зүүн ба зүүн хойт талаас нь дайрч Хүрээн дэх Хятадын гэмн цэрэгтэй байлдаж эхэлжээ. Унгерний цэрэг 13 мянган хүнтэй гэсэн цуурхал тарааж, түүнийгээ нотлохын тулд шөнийн цагаар ууланд олон түүдэг асааж их л сүрлэг байдал үзүүлэн дайсныхаа зориг хүчийг мохоох арга хэрэглэж байв. Монгол цэргийн жанжин Лувсан, Саж лам хоёр гэрийн хорионд байсан Богд хааныг суллан хамгаалсан нь хүн амын өргөн хэсгийн талархал хүлээж Унгерний нэр хүндийг ихэд өргөсөн билээ. Цагаантнууд Монгол цэргийн хүчинд тулгуурлан Хятадын цэргийг хялбархан дийлж 1921 оны 2 дугаар сарын 3-нд Хүрээг эзлээд мөн сарын 21-нд Богд хааныг эрдэнийн ширээнд нь залж өргөмжлөн автономит засгийг сэргээв хэмээн зарлаж Жалханз хутухт Дамдинбазар тэргүүтэй засгийн газрыг байгуулав. Уг засгийн газрын бүрэлдэхүүнд Ерөнхий сайд бөгөөд Дотоод яамны сайдал Дамдинбазар, Гадаад яамны тэргүүн сайдал их шавийн Шанзуб Дашжав, Цэргийн яамны тэргүүн сайдал сэцэн хан аймгийн бишрэлт гүн Доржцэрэн, Сангийн яамны тэргүүн сайдал Түшээт хан аймгийн тэргүүн зэрэг тайж Лувсанцэвээн, Шүүх яамны тэргүүн сайдал Сайн ноён хан аймгийн бэйс Чимиддорж, Монгол бүх цэргийн жанжинд Хатанбаатар ван Магсаржавыг томилон⁵ Богд хаантаа сонсгон айлтгаж зөвшөөрүүлээд Богд хааныг Эрднийн сууринд залах ёслол үйлдсэн өдөр зарлиг буулган сайд, жанжнуудад тамгыг гардуулжээ.

Мөн өдөр Богд хааны хишиг зарлиг буулгасны дотор эн тэргүүн гавъяа байгуулсан орос жанжин барон Унгернд ханы зэрэг, дархан хошой чин вангийн хэргэм ногоон жууз, шар хүрэм жолоо, улсыг мандуулагч их баатар жанжин цол, генерал Резухинд чин вангийн хэргэм, шар хүрэм жолоо, сайшаалтай баатар жанжны цол, буриад Жигмиджав Жамбалонд чин вангийн хэргэм, шар хүрэм хүрэн жолоо, чин зүтгэлт жанжин цол, Монгол жанжин Лувсанцэвээнд чин вангийн хэргэм, шар хүрэм, хүрэн жолоо, бат ерөөлт жанжин цол, албат ардыг цэрэгт элсээж хүчийг зузаатган биесээр баатарлан зүтгэсэн хичээнгүй баатар гүн Найданжавт чин вангийн хэргэм, шар хүрэм, жолоо, сүрийг бадруулагч жанжин цол, баатар гүн Жамцад бэйлийн зэргэ, бэйсийн хэргэм, хоёр нүдэт тогосын отго шагнав.⁶ Монголын нутгийг эзлэн түрэмгийлж байсан Хятадын цэрэгт шийдвэрлэх цохилт өгч Нийслэл Хүрээг чөлөөлсөн Унгерний ялалт бол тусгаар тогтнолынхоо төлөө амь бие үл хайрлан тэргүүн эгнээнд ямагт тулалдаж байсан монгол цэргийн ялалт, тэднийг дэмжин тусалж, ханган нийлүүлж байсан ард олон, Хүрээний оршин суугчдын ялалт байв. Энэхүү үйл явдал нь билний

хэлж дассанчилан түрэмгийлэн эзлэлт бус, харин үндэсний эх оронч хүчин шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн чөлөөлөгч шинж чанараар тодорхойлогдож байна. Эхэлж ялагдсаныхаа дараа Унгерн монголчуудыг цэрэгтээ олноор элсүүлж, хүч, хэрэгслээ сэлбэсний ачаар л амжилтанд хүрч чадсаныг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Ялалтад дөхөм үзүүлсэн нэг хүчин зүйл бол Хятадын цэрэг төвөөс аливаа дэмжлэггүй, Хятадын төв засгийн газар сул дорой, цэрэг улс төрийн дотоод хямралдаан ихтэй байсан явдал мөн. Хэдийгээр Унгерн Богд хаан ба лам нар, сүсэгтэн олонд итгэгдэхийн тулд монголын харьяат болж, буддын шашинд орж, монгол дээл өмсч монгол гэрт сууж байсан боловч цаашдын ажиллагаа нь чөлөөлөх шинж чанарт шууд харш, харгис түрэмгий чиглэлээр өрнөсөн билээ.

Хятадын цэрэг Монголд ялагдал хүлээсний дараа буюу 4-р сард Хятадын засгийн газрын бага хурал Манжуур дахь генерал Жан Золинд Унгерний эсрэг цэргийн аян зохион байгуулах өргөн хэмжээний бүрэн эрх, шаардагдах зэвсэг хэрэгсэл олгохоор шийдвэрлэсэн байна. Гэвч Жан Золин Монголтой зууралдаж, хятад дахь өөрийн байр суурийг сулруулахыг хүсээгүй ажээ. Япончууд ч түүнийг Унгернтэй мөргөлдүүлэхийг хүссэнгүй. Унгерн ч үүнийг бас хүсээгүй байна. Унгерн Жан Золины ойр дотнын нэгэн болох генерал Жан Куньюд 1921 оны 3 дугаар сарын 2-нд бичсэн захидалдаа Чин улсыг сэргээхийн төлөө тэмцлийн удирдагч нь “эрхэм дээд Жан Золин болох ёстой. Жолоодогч генерал Жан Золины ерөнхий удирдлагын дор хаант ёсыг сэргээн тогтоох ажилд туслахад бэлэн”⁷ гэдгээ тэрээр илэрхийлжээ.

Унгерн хэрэг дээрээ Хүрээний эзэн суугаад өөрийнхөө “чөлөөлөгч”, “сэргээн мандуулагч” үүргийн тухай, өөрийн стратегийн зорилгын тухай байнга давтан сануулж байв. 1921 оны 4,5 дугаар саруудад түүнээс Бээжингийн засгийн газар, Далай лам, Жан Золин, Семенов, Пу И, Дотоод Монголын ноёд, казахийн хаад, дөрвөдийн ноёд болон Бээжин, манжуур дахь тагнуул төлөөний хүмүүстээ бичсэн захидлууд энэ тухай гэрчлэх бөгөөд тэдгээрт өөрийн төлөвлөгөө зорилтын тухай тодорхой тайлбарлаж хамтран ажиллахыг уриалж байжээ⁸. Унгерний шүүхэд өгсөн мэдүүлгээр эдгээр захидлын нэгд нь ч хариу ирүүлээгүй байна. Эдгээр захидал нь Унгерн үйл ажиллагааны нэлээд төлөвшсөн тодорхой программтай болоод байсныг харуулж байна. Тухайлбал, Халхыг Хятадаас чөлөөлөх, Богд гэгээний ивээлийн дор монголын бүх газар нутгийг нэгтгэх, “Их Монгол”, Төвд, Синьзяныг багтаасан Төв азийн холбоот улс байгуулах, Хятадал Чин улсын хаанчиллыг сэргээх зорилтууд тусгагджээ. Ингэхлээр Унгерний монгол дахь ажиллагаа зөвхөн Монголоор үл хязгаарлагдах өргөн хүрээтэй төлөвлөгдөж байжээ. Монгол дахь Унгерний бүх үйл ажиллагаа

харьцангуй бие даасан бөгөөд Семеновтой ч, японтой ч огт холбоогүй гэдгийг Унгерн өөрөө шүүх хурал дээр мэдэгджээ. Ингэхлээр түүнийг Японы туршуул, хөлсний этгээд гэх мэтээр үзэж байсан тухай ойлголт нь үндэслэл муутай юм байна.

Унгерний ардчиллын эсрэг, хувьсгалын эсрэг, бүгд найрамдах засаглалын эсрэг хатуу байр суурь, хаант засгийг баримтлагч үзэл нь түүнийг Монголын дарангуйлан захирагч болон хувирахад хүчтэй нөлөөлсөн нь эргэлзээгүй. Тэрээр Хүрээг эзэлмэгцээ л ардчилсан үзэлтний эсрэг харгислал, яргалал явуулсан билээ. Цагаантнуудын хүчирхийлэл, дээрэм, аллага ерийн үзэгдэл болж, тэдний цэргийн хүнс, хэрэгслийг ханган нийлүүлэх хүнд дарамт бас л ард түмнийг хүндээр нэрвэж байлаа.

Монголыг эзлээд явуулж байгаа ажлынхаа талаар Унгерн Бээжин дэх өөрийн төлөөний хүнд 1921 оны 5 дугаар сарын 20-нд бичсэн нэг захидалдаа өөрийн ажил байдал цаашдын бодлынхаа талаар дурдахдаа: “Одоо бидний эзлээд байгаа нутаг дэвсгэрт Хятадын хувьсгалт цэргүүд үлдээгүй. Тэдний гол хэсэг бүрэн цохигдож устав. Үлдсэн хэсгүүд нь Монголын нийслэлээс алсад тэнүүчилж байна. Дотоод, Гадаад Монголыг нэгтгэх Баруун ба Зүүн Монгол аймгуудыг Их Монголын бүрэлдэхүүнд оруулах компани амжилттай явагдаж байна. Одоогоор хувьсгалт хятадын түрэлтийн эсрэг найдвартай түшиг болох зүүн монголын мужуудад гол анхаарлаа хандуулж байна, баруун Монголыг нэгтгэн авах ажиллагаа явуулах болно”⁹ гэжээ.

Их Хүрээг чөлөөлж Монголын засгийн газрыг сэргээн байгуулсан явдлыг гадаад, дотоодод зарлахад Дундат Иргэн улс ба Орос Улсад зарлан мэдэгдэх эх бичгийг Унгерний заавраар бэлтгэн илгээжээ. ДИУ-ын Их Жунганд илгээсэн бичигт Богд Жавзундамба хаантан хуулийн ширээнд суусныг Дундат улсын сюзернетийн дагуу мэдэгдээд Дундат Улсын хууль дүрмийг зөрчиж, хүрэн дэх Их сайдын эрхийг эвдсэн буруу санаат сайд Го Сынлин, Цу Ложан нарын цэрэгтэй байлдсан нь Дундат улстай холбоо таслах ба гэрээ бичгийг эвдэх гэсэн бус, харин Богд хаантныг дарлан барьж язгуурын холбоот Дундат их улсын эрхийг эвдэх гэсэн ба мөн муу дээрэм зэргийг үйлдэж, Оросын улаан намтай нийлэх болсон сайд Го Сынлингийн цэрэг лүгээ байлдахаар монголчууд барон Унгерний цэрэгтэй нийлэхээс өөр замгүй болсон зэргийг учирлан тайлбарлажээ. Энэхүү бичигт дурдсанаар Монголын засгийн газар барон Унгернд хандаж одоо нэгэнт Го Сынлин цэргийн хамт Монголын хязгаараас зайлсан тул Монголд гадаадын цэрэг байх нь зохисгүй гэж мэдэгдсэн бөгөөд Унгерн ч үүнийг зөвшөөрч би өөрийн цэргийг авч Хойт зүг явна гэсэн хариу өгсөн байна. Иймэрхүү утгатай бичгийг Хятадын зүүн хойт мужуудыг захирагч Жан Золин,

Хөлөнбуйрын Мээрэнгийн зангийн яамнаа тус тус илгээсэн байна.

Монголын автономит засгийн газрын нэрээр Орос улсын гадаад хэргийн ардын комиссарт явуулсан бичигт мөн Богджавзундамба хутагтыг дахин хаан ширээнд нь залсныг мэдэгдээд Хятадын цэргийг Монголын нийслэл Хүрэнээс орос лугаа хүчин хавсарч хөөн гаргасан бөгөөд энэхүү орос нар эрхэм комиссар та нар лугаа санаа нийлэхгүй эсэргүүцэн буй явдлыг бид мэдмүй гэж онцлоод, энэхүү орос цэргүүд баруун зүгт одохыг завдан буй тул Орос Монгол хоёрын найрамдалд саад хийх зүйлгүй буй за хэмээн манай Монгол засгийн газар санамуй гэснээс үзэхэд барон Унгерн аяллынхаа чигийг зориуд буруу зааж төөрөлдүүлэх санаа агуулсан бололтой. Олноо өргөгдсөний 11 дүгээр цагаан сарын 25 хэмээсэн энэхүү бичгийг зайсан лам Эндэнданзан ба “Унгерний байдлын шинж чанарыг хянан мэдэх, тэдний гараар гэминг зайлуулах бодлого тавьж” цагаантны цэрэгт орж ажиллаад цагаантны хяналтаас нэвтрэн гарах арга зам хайж байсан Д.Бодоо нар зохих газарт хүргэжээ. Энэ завшааныг ашиглан Д.Бодоо буцах замдаа Хиагтын зүг одож МАН-ын нөхөдтэй нийлсэн юм.

Хэрэг дээрээ Монголд хоёр засаг тогтоод байсан тухайн нөхцөлд тэдгээр бичигт нааштай хариу хүлээх үндэсгүй байв. 1921 оны 3 дугаар сараас Монголын Ардын түр засгийн газартай нягт холбоотой ажиллаж байсан Зөвлөлт Оросын засгийн газар Унгернийхны тогтоосон засгийн газартай харилцах аливаа боломжийг эрс няцаасан бол Хятадын эрх баригчид түүнтэй ямар ч хэлэлцээр хийхгүй, Гадаад Монголд шинэ залхаан цээрлүүлэх анги явуулахыг зэхэж байв. Нийслэл хүрээг чөлөөлсний дараа барон Унгерний явуулсан цэргийн томоохон ажиллагаа бол Чойр дахь хятад цэргийн хүчийг хөөн зайлуулах явдал байв. Өндөр Дугаржав мэйрэнгийн нэгэн хороо цэрэг Чойрыг дайрч хятад цэргийн хүчийг дийлж чадаагүй учир гэмингүүдийн харгислал, дээрэм тонуул улам ширүүссэн юм. Иймд бүх цэргийн жанжин Хатанбаатар Магсаржав, барон Унгерн нар цэрэг авч тэдгээр бүлэглэсэн хятад цэргийн их төлөвийг устган үлдсэн хэсгийг үлдэн хөөсөөр Замын үүд хүрч улмаар дотоод чуулганы нутагт ортол зайлуулжээ. Монгол дахь Унгерний ажиллагааны хамгийн дарамттай тал нь Зөвлөлт Оростой байлдах бэлтгэлээ хангахын тул монголчуудыг цэрэгт дайчлах, цагаантны олон мянган орох оронгүй цэргийг тэжээх, ханган нийлүүлэх явдал байв. Орос, Монгол хамтарсан бүх цэргийн хэрэглэлийг хүрээний харъяат аймаг, шавьд албадан тулгаж гаргуулахад урьд нь хятадад дарлагдан талхигдаж хүчин мөхөсдсөн ард олон амсхийх завдал болоогүй ийнхүү шинэ шинэ ачааллыг дааж давах аргагүй болж байжээ. Ойр орчмоос нийлүүлэх мал олдохгүй болж арав хорин өртөөний чанадаас нүдэнд үзэгдсэн хэрэглэж болохуйц морь,

тэмээ, үхэр, хонь малыг хэд хэдэн зуу, мянгаар хөөн авч ард олныг өчүүхэн ч үл хайрлан хоосруулах болжээ. Барон Унгерний сан маш их хөрөнгөтэй болсон атал түүнээс цэргийн хэрэгцээнд огтхон зарцуулддаггүй, харин ч хураан аживжуулсаар байв. Түүний сан хөрөнгийг мянган тэмээн тэрэг ачиж нүүлгэн туул голын шугуйд буулгасан тухай мэдээ бий. Хүрээнд хятадын эзэнгүй орхигдсон бараа зүйлийг олзолж, хятад банк дээрэмдэх зэргээр баяжсан нь туйлд хүрчээ. Хүрээнд армийн хэрэгцээнд зориулсан оёдлын, гутлын, тоноглолын жижиг үйлдвэрүүд нээх, улс орны худалдаа, санхүүг энэ зорилгод захируулан сэргээх оролдлого хийж, банк нээх, цаасан мөнгө барлан гаргаж байжээ. Монголын хөрөнгөөр хүнс, агтыг хүрэлцэхээр бэлтгээд зогссонгүй, Зөвлөлт Оростой байлдах цэргийн тоог нэмэгдүүлэхийн тулд Монголын газар орон, зах хязгаарыг батлан хамгаалах нэрийдлээр халхын аймгуудаас 3000 цэрэг дайчлан гаргахыг цэргийн яаманд тушааж байжээ. Жавзандамба хутагтын шавь, лам нарыг ч цэрэгт дайчлах болсон байна. Шинээр дайчилсан цэргүүдээс Хүрээний баруун этгээдэд гүн Түвдэндоржийн хошуу, баруун хойт этгээд гүн Сундуйн хошуунд тус бүр 500 цэрэг томилон суулгаж тохинуулах сайдад гүн Балжинням, гүн Сундуйг тус тус томилон захируулж дараагаар нь Сундуйн цэрэгт хоёр зуугаад хүн нэмж хойт зүгээс эргэн ирж байсан гэмнэгээс сэргийлэх арга хэмжээ авчээ. Барон Унгерн баруун хязгаар тохиноогүй тул Хатанбаатар Магсаржавыг биеэр явж баруун хоёр аймгийн цэргийг татан авч зах хязгаарыг сэргийлэн бататгах үүрэг хүчлэн тулгаж явуулаад бүх цэргийн жанжны тамгыг буриад ван Жигмиджав Жамбалонд шилжүүлсэн байна. Энэ нь эрх мэдэл, цэрэг хөдөлгөх асуудлыг нэгэн гарт төвлөрүүлэн чөлөөтэй ажиллах гэсэн зорилготой байв. Мөн Богд хааны зарлиг гаргуулж, түүнд орос жанжин барон Унгерн Монголын харъяат аливаа газар оронд цэрэг дайчлах, уналга, хүнс хэрэглэл татах зэргийн хэрэг учир тохиолдвоос олон харъяат газар орны засаг, түшмэд, ардууд даруй түргэнээ тушаал зарилагийг хүндэтгэн дагаж нийлүүлэн өгч туслан залгамжлуулбаас зохих ба дэмий гэдэсхийн ойшоохгүй байж үл болмуй. Хааяа зорчигчид буй аваас хүндэд цээрлүүлэн шийтгэгтүн гэж заажээ¹⁰.

Ийнхүү барон Унгерн цэрэг, хэрэглэл дайчлах бүрэн эрхийг гартаа авч ямар ч эсэргүүцэлгүйгээр санасан зорьсноо биелүүлэх болжээ. Тэрээр Монголд сууж байсан худалдаа, үйлдвэрийн оросууд ба хязгаар нутгаар тархсан цагаан үзэлтэй оросуудыг цуглуулан авахын тулд Монголын өртөө ба уургын улаагаар зүг зүгт орос элч зарж Улиастай, Ховд, Заяын Хүрээ, Хиагтын хоёр талын харуул зэрэг газруудад суусан оросуудад хэл мэдээ хүргэж татан авах, янз бүрийн хэсэг бүлгүүд байгуулах ажлыг эрчимжүүлэв. Үүний дүнд Түшээт хан

аймгийн Эрдэнэ ван Намсрайн хошуунд сууж байсан атаман Сухарев гэгч тэр хавийн орос, монгол нийлсэн хүмүүсийг элсүүлэн нэгэн хороо болгосон, Хатгал харуулын орчим байсан хурандаа Казагранд тэр хавийн оросуудаас 100 орчим хүнийг элсүүлэн, улмаар Дайчин вангийн хүрээнд хүрч тэндээс орос, монгол хүмүүс нэлээдийг нэгтгэн авч бүгд 500-гаад цэрэгтэй хороо байгуулж ойр хавийн хошуу нутгаас агт хүнсийг албадан дайчлах, худалдааны иргэдийг дээрэмдэх зэргээр хүчээ зузаатгах болов. Мөн Заяын хүрээ, Улиастай, Ховд, Алтайн Урианхай, Дорнод Монголын нутагт суусан оросууд янз бүрийн бүлэг болон зохион байгуулагдаж гүйвээж байв. Тагна Урианхайд байсан орос жанжин Казанцев гэгч харгис гэмийг хөөн зайлуулах нэрийдлээр Урианхайн олон хошуу, сумдаас цэрэг, хэрэглэлийг дайчлан улмаар Улиастайд ирэхэд Улиастайн ёст бэйл Чүлтэм оросуудын дураар дайчлахыг зогсоон, монгол хүнийг цэрэгт дайчлуулж чадахгүй хэмээн эсэргүүцсэн байжээ. Үүнийг барон Унгерн мэдмэгцээ их хэргийг саатуулан боогдуулах муу үлгэр болох аюултай гэж үзээд буриад Вандановт даалгавар өгч Чүлтэмыг хороолгосон юм. Ер өчүүхэн төдий санаанд эс нийлүүлбээс шууд цаазлан цээрлүүлэх нь барон Унгерний номхтгон захирах, айлган сүрдүүлэх арга болжээ. Энэ нь Монголд Унгерний байр суурийг сулруулах, хүн амын дургүйцэл, эсэргүүцлийг төрүүлэх үндэс болов.

Монгол дахь Унгерний байдал улам улам бат биш болж байлаа. Азийн дивиз болон өөрийн цэргийн ангиудыг хангах явдал монголчуудыг улам хүндээр нэрвэх болов. Цагаантнууд Монголын хүн амаас албадан хураах, шууд тонон дээрэмдэх, үл дагагсадыг зэрлэгээр гэгсгээх явдал газар авч, Унгерн өөрөө ч хянан барьж чадахгүй хэмжээнд хүрчээ. Дургүйцэл, эсэргүүцэл газар сайгүй өсөн нэмэгдэж байв. Армид хүчээр дайчлах нь явуургүй болж нэгдсэн ангиудад албан хаахыг хүсэх монголчуудын тоо цөөрсөөр байв. Унгерний төлөвлөгөө Монголын дотор болон гадаадад дэмжлэг олж чадсангүй. Нягт хамтын ажиллагаа тогтсонгүй, дургүйцэгчид, гомдоллогчид, шууд эсэргүүцэгчид нэмэгдсээр байв. “Чөлөөлөгчийг” нэг хэсэг нь хүсэшгүй зочин, нөгөө зарим нь булаан эзлэгч, дээрэмчин, тэжээвэр этгээд гэх мэтээр нэрлэх болжээ. Унгерн 1921 оны 4 дүгээр сарын эцсээр байдлыг өөртөө ашигтайгаар эргүүлэх сүүлчийн оролдлого хийж Богд хаанд захидал бичжээ¹¹. Уг захидалд улс орны дотоод үзэшгүй гутрам өнгө төрхийг дүрслэн бичээд, сангийн хөрөнгийг идэж шамшигдуулан, замбараагаа алдсан түшмэдүүдийн чармайлт чадварт найдах аргагүй болсныг тэмдэглэж хэрэг дээрээ Унгерн өөрийгөө төрийн бүхий л хэрэгт цорын ганц тэнцэх зөвлөгч болгон харуулжээ. Тэрээр ордны дотор өөрийн байр байдлыг бататган, эрх засгаа бэхжүүлэхэд Богд хааны дэмжлэгийг авахаар тоолсон боловч

Богд хаан түүнд хариу өгсөнгүй.

Ийм нөхцөлд Унгерн аль нэг тийш бага ч гэсэн цэргийн амжилттай ажиллагаа явуулж байдлаа дээрдүүлж болох юм гэж шийджээ. Ингээд, умрын аянаа эхэлсэн юм. Энэ үед Семеновоос Унгернд захидал ирүүлж улаантнуудын эсрэг японы дэмжлэгтэйгээр бэлтгэж буй Хятад Оросын хилийн дагуу явуулах цагаан цэргийн өргөн хэмжээний ажиллагаанд оролцохыг санал болгосон байна. Унгерн Байгалийн зүг хөдөлж Улаан-Үдийг авах ёстой болжээ. Гэвч Унгернээс өөр хэн ч байрнаасаа хөдлөөгүй юм. Энэ бол япончууд Семеновоор уламжлан Унгернийг Монголоос хуурч гаргаад Жан Золинд байрыг нь чөлөөлж өгөх гэсэн арга мэх төдий зүйл байсан бололтой. Жан Золин Монгол дахь Унгерний байдал бат бус гэдгийг мэдэж байсан учир түүнийг умар зүг хөдөлсний дараа 6 дугаар сард Монголд халдан орох аятай цаг ирлээ гэж шийдсэн боловч Зөвлөлт Оросын цэрэг өрсөж орсон учир түүний төлөвлөгөө биелээгүй юм. Унгерн 1921 оны 5 дугаар сарын 21-нд “Зөвлөлт-Сибирийн нутаг дахь оросын отрядуудад” гэсэн 15 тоот тушаалдаа¹² даруй эхлэх гэж буй байлдааны ажиллагаанд цэргийн хүчийг тарааж байрлуулах төлөвлөгөө хийгээд Орос ба Монголд явагдаж буй өөрчлөлтийг хэрхэн үнэлж байгаагаа тодорхой тайлбарлажээ. Тушаалд: “1905 он, дараа нь 1916-1917 онууд хувьсгалын жигшүүртэй, ялт үр төрүүлж Орос орон хурдан нуран уналаа. Ард түмний өвөрмөц соёлыг устгах үзэл санааг тээж явдаг большевикууд гарч ирээд эвдрэл сүйрэл туйлдаа хүрэв. Орос орныг хэсэг хэсгээр нь шинээр дахин байгуулах хэрэгтэй”, “миний дивиз монголын цэрэгтэй хамтран Монгол дахь хятадын хувьсгалч большевикуудын хууль бус засгийг түлхэн унагаж тэдний зэвсэгт хүчийг устган, Монголыг нэгтгэхэд чадах чинээгээрээ тусалж, түүний хууль ёсны дээдэс тэргүүн Богд хааны засгийг сэргээн босгов. Энэхүү ажиллагааг дуусгаснаар Монгол нь Зөвлөлт Сибирийн Улаан армийн эсрэг довтолгооныг эхлэх жинхэнэ гарааны газар болов”. Мөн “Уссурийн хязгаараар атман Семеновын цэрэг давших болно. Би атман Семеновт захирагдаж байгаа” гэх мэтээр байдлыг дэлгэрэнгүй тодорхойлжээ. Тушаалд бас томоохон бус нутаг, мужуудыг чөлөөлөхийг хайхрахгүй, зөвхөн өөрийнхөө суурин, тосгоны төлөө дайтах бол учир зүйгүй ичгүүртэй хэрэг мөн. Тиймэрхүү зан авир бол эх орныхоо өмнө үл оролцогч гэмтэн болж төрөөс уравсан явдалд тооцогдоно. Комиссарууд, коммунистууд, еврейчүүдийг гэр бүлийн хамт устгах хэрэгтэй, тэдний бүх хөрөнгийг хураах хэрэгтэй. Оросыг эвдэн бусниулагчид ба гутаагчидын хувьд ганц л шийтгэл - цаазаар авах ял байх болно. Хүнс тэжээлийг хүмүүсээс шууд хураан авах хэрэгтэй гэж тушаажээ.

ИШ ТАТСАН СУРВАЛЖ, БҮТЭЭЛ

1. Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид. “Монгол Ардын үндэсний хувьсгал анх үүсч байгуулагдсан товч түүх” хоёр удаагийн хэвлэл. УБ, 1979. 33 дахь тал.
2. Л.А.Юзерович “Самодержец пустыни. Феномен судьбы барона Р.Ф.Унгерн-Штернберга”, М., 1993, 235 дахь тал.
3. Н.Магсарав. “Монгол Улсын шинэ түүх”. УБ, 1994. 175 дахь тал.
4. Б.Д.Цыбиков. “Разгром унгерновщины”. Улан-Удэ. 1947, 19 дэх талд. Мөн Л.А.Юзерович “Самодержец пустыни”. 73-74 дэх талд үз.
5. Н.Магсаржав. “Монгол улсын шинэ түүх” УБ., 1994, 192 дэх тал.
6. Мөн тэнд 192-193 дахь тал.
7. **Л.А.Юзерович. “Самодержец пустыни” 225 дахь тал.**
8. Мөн тэнд. 137 дахь талд үз.
9. Мөн тэнд. 227 дахь тал.
10. Н.Магсаржав “Монголын шинэ түүх” 201-203 дахь талд үз.
11. Л.А.Юзерович “Самодержец пустыни” 167 дахь талд үз.
12. Мөн тэнд. 230-233 дахь талд үз.

(Үргэлжлэл дараагийн дугаарт)